



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСӨВТ ӨРТГИЙН НЭМЭГДЭЛ ЗАРДАЛД ДҮГНЭЛТ ГАРГУУЛАХААР ИРҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 62.7 ХУВЬ НЬ ЗУРАГ ТӨСЛИЙН АЛДААТАЙ, АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭГ ЗУРГААС ИЛҮҮ ТООЦСОН, ДАВХАРДУУЛСАН, МАТЕРИАЛЫН ҮНИЙГ ӨСГӨСӨН ЗӨРЧИЛ НИЙТЛЭГ БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ӨМНӨХ ОНУУДАД АЖИЛ НЬ ЭХЭЛСЭН БОЛОВЧ ТӨСӨВТ ӨРТӨГ НЭМЭГДЭЖ БАЙГАА БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТӨСӨВТ АУДИТЫН ДҮГНЭЛТ ГАРГАХ
АУДИТЫН КОД: ГНАГ-2025/23-ШТА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2025 он

Гүйцэтгэлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор **Д.Энхболд**

Утас: 263755 Цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn

Аудитын менежер **Ю.Энхтуяа**

Утас: 261805, цахим хаяг: enkhtuyayu@audit.gov.mn

Ахлах аудитор **У.Оюунхүү**

Утас: 261456, цахим хаяг: Oyunkhuu@audit.gov.mn

Ахлах аудитор **С.Дарьмаа**

Утас: 261456, цахим хаяг: Darimaas@audit.gov.mn

Ахлах аудитор **Ш.Дэлгэрмаа**

Утас: 261456, цахим хаяг: Delgermaash@audit.gov.mn

Аудитор **М.Доржмаа**

Утас: 261456, цахим хаяг: dorjmaam@audit.gov.mn

Аудитор **Б.Ууганбилэг**

Утас: 261456, цахим хаяг: uuganbilegb@audit.gov.mn

Аудитор **Д.Нямжаргал**

Утас: 261456, цахим хаяг: Nyamjargald@audit.gov.mn

Аудитор **Б.Идэрбалжинням**

Утас: 261456, цахим хаяг: iderbaljinnyamb@audit.gov.mn

Аудитор **Б.Мөнх-Эрдэнэ**

Утас: 261456, цахим хаяг: munkherdeneb@audit.gov.mn

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	5
ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ	5
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	5
ТӨРИЙН АУДИТЫН СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ	6
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	10
Монгол Улсын төсвийн тухай хуулиар баталсан барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ	10
Өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ	11
Аудитын дүгнэлтэд хамрагдсан төсөл, арга хэмжээний хамрах хүрээ	11
Төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн өөрчлөлт	12
БҮЛЭГ 1. ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАЖ БАЙГАА НЬ ХУУЛИАР БАТАЛСАН ТӨСӨВТ ӨРТГИЙН ДҮН НЭМЭГДЭХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ БАЙНА.....	15
Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуульд тусган баталж байна	15
Төсөвлөлтийн шаардлагад нийцээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж байна	17
Барилгын төсөвт өртгийн өөрчлөлтийг томсгосон хэлбэрээр тооцох аргачлалыг мөрдөж ажиллахгүй байна	17
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨЖ, ТӨСӨВТ ӨРТГИЙГ ТООЦОХДОО, ХУУЛЬ ТОГТООМЖ, НОРМ ДҮРМИЙН ШААРДЛАГЫГ БҮРЭН БАРИМТЛАХГҮЙ БАЙНА.....	19
Барилга байгууламжийн төсөвт өртгийг магадлалаар баталгаажуулахдаа зураг төсөл, төсвийн тооцооллын алдааг залруулаагүй байна	19
Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах эрх бүхий байгууллагын давтан гаргасан алдаанд хариуцлага тооцож зураг төслийн ажлын чанарыг сайжруулах шаардлагатай байна.....	20
БҮЛЭГ 3. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, МАГАДЛАЛ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛЖ ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ ШААРДЛАГА ҮҮССЭН БАЙНА.....	21
Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.....	21
Төсвийн ерөнхийлөн захирагчдын улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, төсөвт өртөгт тавих дотоод хяналт хангалтгүй байна	24
ӨМНӨХ АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ, АЛБАН ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТ	
25	
ДҮГНЭЛТ	27

ЗӨВЛӨМЖ	28
----------------------	-----------

АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛ, ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ
29

ХАВСРАЛТ	34
Хавсралт 1. Аудитын дүгнэлт гаргах төсөл, арга хэмжээний хамрах хүрээ	34
Хавсралт 2. Захиалагчаас ирүүлсэн төсөвт өртгийн өөрчлөлтийн санал.....	35
Хавсралт 3. Захиалагчаас ирүүлсэн төсөвт өртгийн өөрчлөлтийн саналыг хянаж, аудитын дүгнэлт гаргасан төсөл, арга хэмжээ	36
Хавсралт 4. Аудитаар хянаж, дүгнэлт гаргасан төсөл, арга хэмжээний жагсаалт ..	37
Хавсралт 5. Аудитаар хянаж, мэдэгдэл хүргүүлсэн (дүгнэлт гараагүй) төсөл, арга хэмжээний жагсаалт	44
Хавсралт 6. Аудитаар хянаж, мэдэгдэл хүргүүлсэн, зураг төслийн алдаатай төсөл, арга хэмжээний жагсаалт	47
Хавсралт 7. Аудитын тайлагнах үе шатны дараа хянах төсөл, арга хэмжээний жагсаалт	49
Хавсралт 8. Аудитын илэрсэн алдаа зөрчил, сая төгрөгөөр	50

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ

БтХ	Барилгын тухай хууль
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ШТА	Шууд тайлагнах ажил
ГА	Гүйцэтгэлийн аудит
БС	Боловсролын сайд
ГБХНХС	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗТС	Зам тээврийн сайд
ЗГХЭГД	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга
СС	Сангийн сайд
ССАЖЗС	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
ХББОСС	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭХС	Эрчим хүчний сайд
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОБ	Онцгой байдал
ТЗБ	Төрийн захиргааны байгууллага
МХБ	Мэргэжлийн хяналтын байгууллага
МЕД	Магадлалын ерөнхий дүгнэлт
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Захиалагчаас ирүүлсэн төсөвт өртгийн өөрчлөлтийн санал, аудитаар залруулсан

Хүснэгт 2. Аудитын гүйцэтгэх үе шатанд хянаж, мэдэгдэл хүргүүлсэн ТАХ

Хүснэгт 3. Магадлалаар баталгаажуулсан төсөвт илэрсэн алдаа зөрчил (давхардсан тоогоор)

Хүснэгт 4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт

Хүснэгт 5. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт

Хүснэгт 6. Тайлангийн төсөлд ирүүлсэн санал тусгалтын нэгтгэл

Хүснэгт 7. Тайлангийн төсөлд ирүүлсэн санал, саналыг тусгасан байдал

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртөг, санхүүжих дүн, дүнд эзлэх хувь, 2020-2025 он

Зураг 2. Төсөвт өртгийн нэмэгдэлд дүгнэлт гаргуулах төсөл, арга хэмжээний тоо

Зураг 3. Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, түүний өөрчлөлт

Зураг 4. Төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй ТАХ

Зураг 5. Барилгын өртгийн индекс, улирлаар

Зураг 6. Зураг төслийг алдаатай боловсруулсан хуулийн этгээд, алдааны давтамж, дүн

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дүрслэл 1. Аудитын дүгнэлт гаргах ТАХ-ний мэдээлэл

Дүрслэл 2. Сангийн яамнаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн 203 ТАХ, байршлаар

Дүрслэл 3. Төсвийн тухай хуулийн төсөвлөлтийн талаарх заалтууд

Дүрслэл 4. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын төсөвлөлтийн шаардлагууд

Дүрслэл 5. Барилга байгууламжийн зураг төсөл зохиох, хянах үйл явцын зохицуулалт (Төлөвлөх үе шат)

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Аудитын дүгнэлт гаргах төсөл, арга хэмжээний хамрах хүрээ

Хавсралт 2. Захиалагчаас ирүүлсэн төсөвт өртгийг нэмэгдүүлэх санал

Хавсралт 3. Захиалагчаас ирүүлсэн төсөвт өртгийг нэмэгдүүлэх саналыг хянаж, аудитын дүгнэлт гаргасан төсөл, арга хэмжээ

Хавсралт 4. Аудитаар хянаж, дүгнэлт гаргасан төсөл, арга хэмжээний жагсаалт

Хавсралт 5. Аудитаар хянаж, мэдэгдэл хүргүүлсэн (дүгнэлт гараагүй) төсөл, арга хэмжээний жагсаалт

Хавсралт 6. Аудитаар хянаж, мэдэгдэл хүргүүлсэн, зураг төслийн алдаатай төсөл, арга хэмжээний жагсаалт

Хавсралт 7. Аудитын тайлагнах үе шатны дараа хянах төсөл, арга хэмжээний жагсаалт

Хавсралт 8. Аудитаар илэрсэн алдаа зөрчил, сая төгрөгөөр

ТӨРИЙН АУДИТЫН СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3, 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын Хорооны 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаартай шийдвэрийг тус тус үндэслэн гүйцэтгэв.
АУДИТЫН КОД	ГНАГ-2025/23-ШТА-НА
АУДИТЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ	“Улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт аудитын дүгнэлт гаргах” нийцлийн аудитыг гүйцэтгэн, үр дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байдал; - Төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг тооцож төлөвлөхдөө холбогдох хууль, журам, норм дүрмийн шаардлагад нийцүүлсэн байдал.
ХАМАРСАН ХҮРЭЭ	Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлж байгаа Төсвийн ерөнхийлөн захирагчид, түүний харьяа байгууллагууд, Барилгын хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв, Зам тээврийн хөгжлийн төвийн холбогдох үйл ажиллагаа, ТЕЗ-аас төсөвт өртгийн өөрчлөлтөд дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн төсөл, арга хэмжээний зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, зураг төсөл зохиох болон ажил гүйцэтгэх гэрээ, зохиогч, захиалагчийн хяналтын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт болон холбогдох бусад баримт, мэдээллийг хамруулав.
АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	Аудитыг АДБОУС 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020, “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020, “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулан дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, асуулга, лавлагаа, тодруулга, судалгаа авах, нэгтгэх, дүн шинжилгээ, тооцоо хийх зэрэг аудитын арга зүйг ашиглаж аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав. Аудитад дараах хууль тогтоомжийг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглаж шалгадагч этгээдийн үйл ажиллагаа нь холбогдох хууль, тогтоомжид нийцэж буй эсэхийг үнэлж дүгнэн аудитын явцад илэрсэн зөрчлийг арилгах зарчмыг баримталлаа. Хууль тогтоомж: ■ Төсвийн тухай хууль; ■ Монгол Улсын төсвийн тухай хууль, нэмэлт өөрчлөлт; ■ Төрийн хэмнэлтийн тухай хууль; ■ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль; ■ Барилгын тухай хууль; ■ Эрчим хүчний тухай хууль; ■ Авто замын тухай хууль;

	▪ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; ▪ Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”; ▪ Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 160 дугаар, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”; ▪ Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”; ▪ ЗТБХБС-ын 2012 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 181 дүгээр тушаалаар баталсан “Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм”; ▪ БХБС-ын 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 30 дугаар тушаалаар баталсан “Төсөв зохиох дүрэм”; ▪ Барилга байгууламжийн батлагдсан зураг төсөл, төсөв, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актууд.
АУДИТЫН БҮРЭЛДЭХҮҮН	Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Ю.Энхтуяа хэрэгжүүлэн, ахлах аудитор С.Дарьмаа, У.Оюунхүү, Ш.Дэлгэрмаа, аудитор М.Доржмаа, Д.Нямжаргал, Б.Идэрбалжинням, Б.Ууганбилэг, Б.Мөнх-Эрдэнэ, гэрээт ажилтан Б.Батбаяр нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв. Хөндлөнгийн, мэргэжлийн шинжээчийн багаар 40 төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт хяналт хийлгэж дүн, дүгнэлтийг аудитад ашиглав.
АУДИТЫН ХЯЗГААРЛАЛТ	Цаг хугацааны хязгаарлалтын улмаас төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг бодит нөхцөл байдалд үзэж хянах боломжгүй байсан тул цаасан болон цахим нотлох баримтын хүрээнд баримт бичгийн шинжилгээ хийж, захиалагч, гүйцэтгэгчтэй ярилцлага, уулзалт хийх, нэмэлт баримт гаргуулан авч нотлох ажлаар хязгаарлагдсан. Цалингийн нэмэгдэл, материалын үнийн өсөлтийг тус аудитад хамруулаагүй болно.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/132

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.3, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.* Улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт аудитын дүгнэлт гаргах* сэдэвт нийцлийн аудитын тайланг Нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг Хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Д.Энхболд)-т даалгасугай.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга (С.Бямбацогт), Сангийн сайд (Б.Жавхлан), Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд (Э.Бат-Амгалан) нарт тус тус зөвлөсүгэй.

4.Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг бүртгэж биелэлтийг хянаж ажиллахыг Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар (Ч.Цэвэгдорж)-т үүрэг болгосугай.


5.Аудитын ажлын баримт болон нотлох зүйлийг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивт хүлээлгэн өгөхийг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Д.Энхболд)-т үүрэг болгосугай.

 С.МАГНАЙСҮРЭН

Z:\Tushaali\2025\EA-In A\Tushaali\1114 GAG-1.Docx

1525010003

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2025 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн 14/32
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



“УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ӨМНӨХ ОНУУДАД АЖИЛ НЬ ЭХЭЛСЭН
БОЛОВЧ ТӨСӨВТ ӨРТӨГ НЭМЭГДЭЖ БАЙГАА БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
ТӨСӨВТ АУДИТЫН ДҮГНЭЛТ ГАРГАХ” АУДИТААР ХҮРГҮҮЛСЭН АЛБАН
ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

№	Хариуцагч байгууллага	Гаргасан шийдэл	Зөрчлийн тоо	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн (сая төгрөг)
1	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	Албан шаардлага	101	Сахилгын шийтгэл ногдуулах	61,665.1
Нийт			101	-	61,665.1

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын төсвийн тухай хуулиар баталсан барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ


Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжүүлэх дүн жил ирэх тусам нэмэгдэж байна.

Тухайлбал, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд 2,896,601.2 сая төгрөгийг барилга байгууламжид зарцуулахаар баталжээ. Энэ нь 2023 онтой харьцуулахад 43.0 хувиар, 2020 онтой харьцуулахад 2.7 дахин өссөн байна.

Харин Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд 2,426,478.6 тэрбум төгрөгийг барилга байгууламжид зарцуулахаар баталсан нь 2024 онтой харьцуулахад 16.3 хувиар буурч, 2020 онтой харьцуулахад 2.3 дахин нэмэгдсэн ба 2016-2025 оны төсвийн жилд дунджаар төсөвт өртгийн 22.7-36.6 хувийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна (2019 он орохгүйгээр).

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь хэсэгт “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилт нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар төлөвлөх” гэж, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5 дахь хэсэгт “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах” гэж тус тус заасан.

Зураг 1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртөг, санхүүжих дүн, дүнд эзлэх хувь, 2020-2025 он




Эх үүсвэр: Монгол Улсын 2016-2025 оны төсвийн тухай хууль

Өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хэрэгжүүлж буй нийт 208 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэлд аудитын дүгнэлт гаргуулахаар Сангийн яамнаас 2024 оны 12 дугаар сараас 2025 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд 9 удаагийн албан бичгээр жагсаалт, мэдээллийг ирүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр баталсан аудитын төлөвлөгөөнд 163 төсөл, арга хэмжээнд аудитын горим хэрэгжүүлж дүгнэлт гаргахаар тусгасан боловч аудитыг гүйцэтгэх, тайлагнах үе шатны хугацаанд 45 төсөл, арга хэмжээг нэмж ирүүлсэн.

Зураг 2. Төсөвт өртгийн нэмэгдэлд дүгнэлт гаргуулах төсөл, арга хэмжээний тоо




Эх үүсвэр: Сангийн яамны мэдээлэл, Аудитын төлөвлөгөө

Аудитын дүгнэлтэд хамрагдсан төсөл, арга хэмжээний хамрах хүрээ


Аудитад хамруулахаар нийт 208 ТАХ-ний жагсаалт ирүүлснээс 5 нь давхардсан ба 203 ТАХ-ний 185 буюу 91.1 хувийг аудитын гүйцэтгэх үе шатанд хянан үзэж 145 буюу 78.4 хувийнх нь төсөвт өртөгт дүгнэлт гаргав.

Аудитын гүйцэтгэх үе шатанд хянаж дүгнэлт гаргаагүй 40 ТАХ-ээс 4 ТАХ-ний нэмэгдэл зардлыг улсын төсвөөс, 7 ТАХ-ний нэмэгдэл зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн нь тогтоогдсон ба төсөвт өртгийг нэмэгдүүлэх шаардлагагүй 5, өмнөх аудитын дүгнэлтийн дүн өөрчлөгдөөгүй 4 ТАХ байна.

Дүрслэл 1. Аудитын дүгнэлт гаргах ТАХ-ний мэдээлэл



Дүрслэл 2. Сангийн яамнаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн 203 TAX, байршлаар




Төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн өөрчлөлт

Аудитын гүйцэтгэх үе шатанд хянаж дүгнэлт гаргасан 145 TAX-ний төсөвт өртөг анх 902,137.6 сая төгрөгөөр батлагдаж байсан бол 1,050,207.7 сая төгрөг болж нэмэгдсэн байв.

Магадлалаар 145 ТАХ-ний нийт төсөвт өртгийг 446,088.4 сая төгрөг буюу 42.5 хувиар нэмэгдүүлэн 1,496,296.2 сая төгрөг байхаар баталгаажуулсан ба захиалагч 521,174.1 сая төгрөг буюу 34.8 хувиар нэмэгдүүлж 1,571,381.8 сая төгрөг байхаар тооцоолсон байна.

Аудитаар 145 ТАХ-ний төсөвт өртгийг 1,408,309.6 сая төгрөг байхаар тооцоолж, захиалагчаас ирүүлсэн төсөвт өртгийг нэмэгдүүлэх саналын дүнгээс 163,072.2 сая төгрөг буюу 31.3 хувь, магадлалаар баталгаажсан төсвийн дүнгээс 87,986.5 сая төгрөг буюу 19.7 хувиар бууруулснаар 68,745.3 сая төгрөгийн үр өгөөжийг бий болгов.

Зураг 3. Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, түүний өөрчлөлт



Эх үүсвэр: Сангийн яамны мэдээлэл, Аудитын дүн шинжилгээний үр дүн

Үндэсний аудитын газраас 2023 онд гүйцэтгэсэн “Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл зардалд дүгнэлт гаргах” аудитаар 313 ТАХ-ний төсөвт өртгийг 823,514.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр санал ирүүлсний 14.6 хувь нь үндэслэлгүй гэж дүгнэсэн бол 2025 онд ирүүлсэн саналын 31.3 хувь нь үндэслэлгүй байна.

Хүснэгт 1. Захиалагчаас ирүүлсэн төсөвт өртгийг нэмэгдүүлэх санал, аудитаар залруулсан

Үзүүлэлт	2023 он	2025 он
Захиалагчаас ирүүлсэн төсөвт өртгийн өөрчлөлтийн санал (сая.төг)	823,514.8	521,174.1
Үүнээс үндэслэлгүй буюу аудитаар хассан дүн (сая.төг)	120,222.1	163,072.2
Алдаа зөрчлийн дүнд эзлэх хувь	14.6%	31.3%

Эх үүсвэр: Сангийн яамны мэдээлэл, Аудитын үр дүн

Мөн захиалагчаас 249,284.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 40 ТАХ-ний төсөвт өртгийг 76,547.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр санал ирүүлснийг аудитын явцад хянаж холбогдох тайлбар, мэдэгдлийг хүргүүлсэн.

Хүснэгт 2. Аудитын гүйцэтгэх үе шатанд хянаж, мэдэгдэл хүргүүлсэн ТАХ

№	ТЕЗ	ТАХ	Сүүлд батлагдсан төсөвт өртөг (сая.төг)	МЕД-ээр батлагдсан төсөвт өртөг			Захиалагчаас ирүүлсэн төсөвт өртөг		
				Бүгд (сая.төг)	Өөрчлөлт (сая.төг)	Өөрчлөлт (%)	Бүгд (сая.төг)	Өөрчлөлт (сая.төг)	Өөрчлөлт (%)
1	БС	23	128,843.2	154,547.1	25,703.88	19.9%	154,089.22	25,245.99	16.3%
2	ССАЖЗС	9	54,326.5	63,666.5	9,339.94	17.2%	70,921.24	16,594.71	26.1%
3	ХББОСС	3	8,869.9	12,940.8	4,070.88	45.9%	16,707.94	7,838.00	60.6%
4	ХХААХҮС	2	9,930.8	28,812.5	18,881.73	190.1%	28,602.48	18,671.68	64.8%
5	ЭМС	3	47,313.9	52,178.2	4,864.29	10.3%	55,510.84	8,196.94	15.7%
	Нийт	40	249,284.4	312,145.1	62,860.7	25.2%	325,831.7	76,547.3	24.5%

Эх үүсвэр: Сангийн яамны мэдээлэл, Аудитын үр дүн

БҮЛЭГ 1. ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАЖ БАЙГАА НЬ ХУУЛИАР БАТАЛСАН ТӨСӨВТ ӨРТГИЙН ДҮН НЭМЭГДЭХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ БАЙНА

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуульд тусган баталж байна

1.1. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн талаарх бүлэг заалтууд, мөн хуулийн 29¹ дүгээр зүйл заалтаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг тус тус заасан боловч хэрэгжилт хангалтгүйгээс ТАХ-ний тухайн жилийн Төсвийн тухай хуульд тусгасан төсөвт өртгийн дүн өөрчлөгдөж байна.

Дүрслэл 3. Төсвийн тухай хуулийн төсөвлөлтийн талаарх заалтууд

01	29 ¹ .2.1. дэх хэсгийн заалт	29 ¹ .2.4.дэх хэсгийн заалт	04
	тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх;	урсгал зардал гарах төслийн урсгал	
02	29 ¹ .2.2.дахь хэсгийн заалт	29 ¹ .2.5.дахь хэсгийн заалт	05
	барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;	тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх.	
03	29 ¹ .2.3.дахь хэсгийн заалт	29 ¹ .2.6.дахь хэсгийн заалт	06
	техник эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай төсөл, арга хэмжээнд техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгааг хийлгэсэн байх;	олон нийтээр хэлэлцүүлсэн байх.	

Эх үүсвэр: www.legalinfo.mn

1.2. Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд тавигдах шаардлагыг нарийвчлан зохицуулсан. Тус журмын 3 дугаар зүйлийн 3.2.2.1-3.2.2.3 дахь хэсэгт барилга байгууламжид тавигдах шаардлагыг, 3.2.3.1-3.2.3.4 дэх хэсэгт их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний төсөл, арга хэмжээнд дараах шаардлагыг, 3.2.4 дэх хэсэгт ТЭЗҮ-тэй холбогдох шаардлагыг тус тус тодорхойлжээ.

Дүрслэл 4. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын төсөвлөлтийн шаардлагууд

Барилга байгууламжийн ТАХ	Их засвар	ТЭЗҮ
3.2.2.1.эрх бүхий байгууллагаас газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх; 3.2.2.2.барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх; 3.2.2.3.шаардлагатай тохиолдолд төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл (цаашид "ТЭЗҮ" гэх), техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа (цаашид "ТЭЗҮС" гэх) хийлгэсэн байх.	3.2.3.1.шаардлагатай тохиолдолд урсгал зардлыг тооцсон байх; 3.2.3.2.төсвийн хязгаарт багтсан, нэн тэргүүний ач холбогдолтой байх; 3.2.3.3.холбогдох баримт бичиг, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх; 3.2.3.4.тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох баримт бичигт үндэслэсэн байх.	3.2.4.ТЭЗҮС, ТЭЗҮ боловсруулах төсөл, арга хэмжээ болон зөвлөх үйлчилгээний ажил нь холбогдох хууль тогтоомжид үндэслэсэн, тухайн байгууллага, эсхүл салбарын зорилт болон дунд хугацааны төлөвлөлтөд нийцсэн, эрэлт хэрэгцээ, бодит шаардлагад тулгуурласан байна.

Эх үүсвэр: www.legalinfo.mn

1.3. Аудитын үр дүнгээр 10 ТЕЗ-ийн төлөвлөсөн 145 ТАХ-ний 7 буюу 4.8 хувь нь "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.2.2.1 хэсэгт заасан эрх бүхий байгууллагаас хэрэгжих газрын зөвшөөрөл авсан байх шаардлагыг, 16 буюу 11.0 хувь нь бусад холбогдох зөвшөөрлийг авсан байх шаардлагыг тус тус хангахгүй байна.

1.4. Мөн барилга байгууламжийн төсөвт өртөг нэмэгдэхэд нөлөөлж буй дараах асуудлууд байна. Үүнд:

- ТӨЛӨВЛӨХ ҮЙЛ ЯВЦЫН ДАРААЛАЛ АЛДАГДСАН**

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуульд тусгаж батлах, батлагдсан төсөвт багтаах зорилгоор ажлын тоо хэмжээг хувааж тендер шалгаруулалтыг зохион байгуулах, гүйцэтгэгчийг шалгаруулсны дараа зураг төслийг баталгаажуулах, санхүүжилтийг боломжтой хэмжээнд төлөвлөөгүйгээс хэрэгжилт удааширч төсөв дахин боловсруулах г.м - **51 ТАХ**
- НЭМЭЛТ АЖИЛ ТӨЛӨВЛӨСӨН**

Анхны зураг төсөлд тусгагдаагүй ажлыг нэмж хийх, техникийн нөхцөл өөрчилснөөс шалтгаалан гадна инженерийн шугам сүлжээнд өөрчлөлт орох, г.м) - **27 ТАХ**
- ЗУРАГ ТӨСЛИЙГ ӨӨРЧИЛСӨН**

Зураг төслийг шинэчлэх, өөрчлөлт оруулах, анхны зураг төслийн алдаанаас шалтгаалж дахин зураг төсөл боловсруулах г.м - **67 ТАХ**


Эх үүсвэр: Аудитын үр дүн

Төсөвлөлтийн шаардлагад нийцээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж байна

1.5. Аудитад хамрагдсан 10 ТЕЗ-ийн багцад хамаарах 145 ТАХ-ний 110 буюу 75.9 хувийг төлөвлөхдөө зураг төсөл, төсөвтэй байх шаардлагыг бүрэн хангаагүй байна.

1.6. Үүнээс ХББОСС, ХЗДХС-ын багцын аудитад хамруулахаар ирүүлсэн 5 ТАХ хэмжээ, Боловсролын сайдын багцын 73 буюу 85.9 хувь, ССАЖЗС-ын багцын 17 буюу 58.6 хувийг зураг төсөлгүйгээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгажээ.

Зураг 4. Төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй ТАХ



Эх үүсвэр: Аудитын үр дүн

Барилгын төсөвт өртгийн өөрчлөлтийг томсгосон хэлбэрээр тооцох аргачлалыг мөрдөж ажиллахгүй байна

1.7. Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 206 дугаар тушаалаар баталсан “Барилгын төсөвт өртгийн өөрчлөлтийг томсгосон хэлбэрээр тооцох аргачлал” (БД 81-104-22)-ын 4.4 дэх хэсэгт барилгын өртгийг цалин, материалын зардлын өөрчлөлт, машин ашиглалтын зардлын өөрчлөлт болон тээврийн зардалд нөлөөлөх суурь хүчин зүйлсээс хамааруулан индексжүүлэх арга зүйг тодорхойлжээ.

1.8. Харин тус арга зүйн дагуу барилга байгууламжийн зураг төсөл, төсөвт өртгийг тооцоход хэрэглээний үнийн индекс, валютын ханш зэрэг суурь хүчин зүйлсийн нөлөөллийг тусган индексжүүлэхгүй байна.

1.9. Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм¹ (ЗЗБНБД 81-013-2019):

- **2.1 дэх хэсэгт** “авто зам, замын байгууламжийн ажлын төсөвт өртөг нь зах зээлийн үнийн тухайн үеийн түвшинд (тооцоо хийж буй тухайн цаг үеийн жишиг үнээр) тооцоологдсон байх ёстой гэж заасан. Харин зам барилгын ажлын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хийхэд ээлжит санхүүгийн жилд гүйцэтгэх ажлын төсөвт

¹ Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 256 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан.


өртгийг үнийн индексийн харгалзах системийг ашиглан, зах зээлийн үнийн хэтийн түвшинд тодорхойлно”;

- **2.2 дахь хэсэгт** “Тухайн жил буюу “зам барилгын ажлын”-д эсвэл жил дамнан үргэлжлэн хийгдэх замын барилгын ажлын төсөвт өртөгт тусгагдах ажилчдын цалингийн тариф, материал түүхий эдийн үнэ, автомашинаар тээвэрлэх ачааны тн.км-ын үнэ, машин механизм, тоног төхөөрөмжийн машин цагийн үнэлгээний өөрчлөлтийг тухай асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулсан индексээр өөрчлөн тооцно” гэж тодорхойлжээ.

1.10. Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/78 дугаар тушаалаар баталсан “Барилга байгууламжийн өртгийн индекс тооцох аргачлал”-ын дагуу барилгын өртгийн индексийн ерөнхий индекс, орон сууцны барилга, инженерийн барилга байгууламж, орон сууцны бус барилгын индексүүдийг 2016 оноос эхлэн өмнөх оны мөн үе, өмнөх оны эцэс, өмнөх улирал болон 2015 оны суурь болгосноор улирал бүр тооцдог байна.

1.11. Тус тооцоогоор 2015 оныг суурь болгосон барилгын өртгийн ерөнхий индекс 2024 оны 2 дугаар улирлаас 2025 оны 2 дугаар улирлын хооронд 2.6-2.7 дахин, үүнээс орон сууцны барилгын индекс 2024 оны 1 дүгээр улирлаас 2025 оны 2 дугаар улиралд 3.0-3.3 дахин өссөн боловч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх барилга байгууламжийн хувьд өртгийн индекс ашиглаагүй, харьцуулсан судалгаа тоон мэдээлэлгүй байна.

Зураг 5. Барилгын өртгийн индекс, улирлаар



Эх үүсвэр: www.1212.mn

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨЖ, ТӨСӨВТ ӨРТГИЙГ ТООЦОХДОО, ХУУЛЬ ТОГТООМЖ, НОРМ ДҮРМИЙН ШААРДЛАГЫГ БҮРЭН БАРИМТЛАХГҮЙ БАЙНА

Барилга байгууламжийн төсөвт өртгийг магадлалаар баталгаажуулахдаа зураг төсөл, төсвийн тооцооллын алдааг залруулаагүй байна

2.1. Магадлалаар баталгаажуулсан зураг төслийг хянахад 16 ТАХ-ний зураг төсөл алдаатай, аудитын явцад залруулах боломжгүй учир зураг төслийн алдааг засварлаж дахин магадлалаар баталгаажуулах шаардлагатай байна. (Хавсралт хүснэгт 6-д дэлгэрэнгүй харуулав).

2.2. Эдгээр ТАХ-ний зураг төсөлд дараах алдаа зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Нэг маягийн зураг төсөлд холболтын тамга дарж баталгаажуулаагүй;
- Магадлалыг иж бүрэн зураг төсөлд хийгээгүй;
- Ажлын тоо хэмжээ зургаас зөрүүтэй, давхардуулан тооцсон, зурагт материалын түүвэр зөрүүтэй;
- Барилгын дотор, гадна шугам сүлжээний зураг хоорондоо уялдаагүй;
- Гадна тохижилтын ажлыг эдэлбэр газраас хэтрүүлэн төлөвлөсөн;
- Шаардлагагүй тоног төхөөрөмж нэмж тусгасан;
- Батлагдсан зураггүйгээр төсөв гүйцэтгэсэн;
- Төсвийн тооцоонд ажилбар давхардуулсан, зарим материалын орц зөрүүтэй;
- Тээвэр, механизмын үнийг нормоос нэмэгдүүлэн тооцсон, тээврийн зай, материалын жин зөрүүтэй тооцсон;
- Гадна инженерийн шугам сүлжээний төлөвлөлт техникийн нөхцөлөөс зөрүүтэй;
- Газар шорооны ажил нь инженер геологийн дүгнэлтээс зөрүүтэй;
- Барилгын үе шатны ажлуудын материал болон тээврийн зардлын тоо хэмжээ зургаас зөрүүтэй тооцсон;
- Механизмын зардлын нэгжийн үнэлгээ зөрүүтэй;
- Нэмэлтээр гүйцэтгэхээр тооцож төсөв боловсруулан батлуулсан ажлын тоо хэмжээ бүрэн нотлогдохгүй зэрэг байна.

2.3. Аудит хийж дүгнэлт гаргасан 145 ТАХ-ээс 58.6 хувь буюу 85 ТАХ-ний магадлалаар хянаж баталгаажуулсан төсвийн дүнг залруулж 87,986.4 сая төгрөгөөр бууруулав. Үүнээс алдаа нь 61,665.1 сая төгрөг байна (Хавсралт хүснэгт 8-д дэлгэрэнгүй харуулав).

Хүснэгт 3. Магадлалаар баталгаажуулсан төсөвт илэрсэн алдаа зөрчил (давхардсан тоогоор)

№	Ангилал	Алдаа, зөрчлийн тоо	Алдаа, зөрчлийн мөнгөн дүн /сая.төг/
1	Материалын үнийг жишиг үнэ, зах зээлийн үнээс өндрөөр тооцсон	26	5,195.8
2	Төсөвт ажлын тоо хэмжээг зураг, материалын түүврээс илүү тооцсон	25	3,758.7
3	Анхны батлагдсан төсөв, гэрээнд тусгагдсан ажлыг нэмэлт ажлын төсөвт давхардуулан төлөвлөсөн	23	9,121.3
4	Хэрэгцээ шаардлагагүй, үр ашиггүй ажлыг хийж гүйцэтгэхээр төсөвт тусгасан	21	6,150.4
5	Ажлын үндэслэлд орсон ажилбарыг ажлын тоо хэмжээнд оруулж давхардуулан тооцсон	15	2,493.4
6	Материалын орцын норм болон механизмын үнэлгээг өөрчилж нэмэгдүүлсэн	9	3,369.5
7	Өмнө хийгдсэн ажлын цалингийн зардлыг шинэчилсэн тарифаар тооцсон	6	1,543.7

8	Тоног төхөөрөмжийн зардлыг материалын зардалд тусгаж шууд зардалд оруулсан	6	41.9
9	Үндэслэх зураггүй төсөв боловсруулсан	3	499.4
10	Төсөл, арга хэмжээний багцад орсон барилгын зураг төсөл алдаатайгаас хэсэгчлэн дүгнэлт гаргасан	1	29,491.0
Нийт		135	61,665.1

Эх үүсвэр: Аудитын үр дүн


2.4. Төсвийн тооцоололд ажлын тоо хэмжээг давхардуулан тооцсон, материалын орц нормыг үндэслэлгүйгээр өсгөж өртгийг нэмэгдүүлсэн, материалын үнийг жишиг үнээс өндрөөр тооцсон, хэрэгцээ шаардлагагүй, үр ашиггүй, үндэслэлгүй ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн зөрчил нийтлэг илэрч байна.

2.5. Барилга байгууламжийн зураг төсөл, төсөвт өртгийн тооцоонд илэрсэн эдгээр алдаа зөрчил нь Барилгын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, “Төсөв зохиох дүрэм”-д нийцээгүй байна.

Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах эрх бүхий байгууллагын давтан гаргасан алдаанд хариуцлага тооцож зураг төслийн ажлын чанарыг сайжруулах шаардлагатай байна

2.6. Зураг төслийг боловсруулахдаа холбогдох норм, дүрмийг баримтлаагүй 65 хуулийн этгээдээс 49 буюу 75.4 хувь нь 29,004.6 сая төгрөгийн 2 хүртэлх удаа, 11 нь 13,605.3 сая төгрөгийн 3-5 удаа, 4 нь 46,698.2 сая төгрөгийн 6-8 удаагийн алдаа тус тус гаргасан байна.

Зураг 6. Зураг төслийг алдаатай боловсруулсан хуулийн этгээд, алдааны давтамж, дүн



Эх үүсвэр: Аудитын үр дүн

2.7. Зураг төслийг боловсруулахдаа холбогдох норм, дүрмийг баримтлаагүй, алдааг залруулаагүй дүгнэлт гаргасан, дүгнэлтийг нэгтгэж баталгаажуулсан байгаа нь Барилгын тухай хуулийн хуулийн холбогдох заалт, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах магадлал хийх дүрэм”-д нийцэхгүй байх тул ХББОСЯ-нд магадлал хийх үйл ажиллагаанд гарч байгаа алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, буруутай байгууллага, албан тушаалтанд хуульд заасны дагуу хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

2.8. Олон улсын түвшинд барилгын мэдээлэлтэй загвар (Building information modeling), хотын мэдээлэлтэй загвар (City information modeling) зэрэг системээр барих

²Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 30 дугаар тушаалын хавсралтаар баталсан.

гэж буй барилга байгууламжийн тухай мэдээллийг загварчлах, удирдах, ашиглах үйл явцыг системчилсэн байдлаар авч үздэг байна.

2.9. Цуглуулсан бүрэн мэдээлэлд үндэслэн эдгээр загварыг хооронд нь холбож, хөгжүүлснээр барилга угсралтын хугацааг богиносгож, чанарыг сайжруулж, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх боломжтой бөгөөд энэ нь төсөлд оролцогч талуудын хооронд мэдээлэл солилцох процессыг хялбар болгох зорилготой байна.

2.10. Тухайлбал, Сингапур, Хятад, Өмнөд Солонгос, Япон, Малайз, БНХАУ-ын Тайван зэрэг Азийн орнуудад тус загварыг сурталчлах үндэсний удирдамжийг бий болгосон байна. Мөн Филиппин, Энэтхэг, Индонез зэрэг хөгжиж буй зарим улс оронд тус загварыг барилгын төслүүдэд хэсэгчлэн нэвтрүүлжээ.

2.11. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж, их засварын ажлын төлөвлөлт, зураг төслийн чанарыг сайжруулахад орчин үеийн дэвшилтэт системийг ашиглах, эрх зүйн орчныг бий болгох шаардлага үүссэн байна.

БҮЛЭГ 3. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, МАГАДЛАЛ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛЖ ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ ШААРДЛАГА ҮҮССЭН БАЙНА

Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна

3.1. Барилга байгууламжийн зураг төсөл, төсөвт өртгийг зохиох, хянах үйл явцын хууль эрх зүйн орчин бүрдсэн байна.

3.2. Барилгын тухай хууль, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэмд барилга байгууламжийн зураг төсөл зохиох, түүнд тавих хяналтыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр зохицуулжээ. Үүнд:

- **Хянах үе шат I: Зураг төсөл зохиогч** өөрөө мэргэжлийн хариуцлага хүлээх үүргийг хүлээсэн байна (БтХ 38.1.2);
- **Хянах үе шат I: Галын аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл шаардлага, техникийн нөхцөл олгох эрх бүхий байгууллага** нь зураг төсөл зохиох эрх бүхий байгууллагын зохиосон зураг төслийг хянан, холбогдох дүгнэлт, шийдвэрийг гаргана (БтХ 11.1.2, 28.2.1);
- **Хянах үе шат II: Зураг төсөл зохиох эрх бүхий хуулийн этгээдийн** захирал барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийх, баталгаажуулах, хариуцлага хүлээнэ (БтХ 38.1.3);
- **Хянах үе шат III: Эксперт** магадлалын дүгнэлт гаргах, мэргэжлийн хариуцлага хүлээнэ (БтХ 39.4);
- **Хянах үе шат IV: Барилгын хөгжлийн төв** нь зураг төсөлд магадлал хийх эксперттэй гэрээ байгуулж, гүйцэтгэлд хяналт тавих (Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийн 6.8.2), захиалагчтай магадлал хийх ажлыг зохион байгуулах, зураг төсөлд магадлал хийх ажлын гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих (Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм 6.8.3);
- **Хянах үе шат V: ХББОСЯ-ны Техникийн улсын хяналт хариуцсан нэгж** барилга байгууламжийн зураг төслийн хэрэгжилтэд (БтХ 47.2.3), барилга байгууламжийн төсөвт өртөг, үнэ бүрдэлд (БтХ 47.2.13), ХББОСЯ нь зураг төсөл зохиогч, барилгын материал үйлдвэрлэгч, гүйцэтгэгчийн техникийн дотоод хяналтын үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавина (БтХ 47.3)

3.3. Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын дүрмийн 4.4.4.4 дэх хэсэгт барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, тэдгээртэй гэрээ байгуулах үйл ажиллагааг зохицуулсан боловч гэрээний хэрэгжилтэд хяналт тавих

үйл явцын зохицуулалтыг тусгаагүй байх ба энэ дүрэм нь Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийн 6.8.2 дахь заалттай бүрэн нийцэхгүй байна.

МЕД-тэй холбогдох үйл ажиллагааны чиглэл

Үйл ажиллагааны чиглэл:

4.2.4 Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах

4.4.4 Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагаа

4.4.4.1 зураг төслийг олон улсын стандартын шаардлагад нийцүүлэх болон хүртээмжийн шаардлагыг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл боловсруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэсэн заавар, журам боловсруулах;

4.4.4.2 Монгол Улсын нутаг дэвсгэрт барих хот, суурин, **барилга байгууламж** (шинээр барих болон засвар, өргөтгөл, хүчитгэх, буулгах, шинэчлэл хийх инженерийн хийцтэй бүх төрлийн барилга байгууламж), **инженер геологи, бүх төрлийн дэд бүтцийн зам, шугам сүлжээний зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах**, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах, зураг төслийн байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, арга зүйн дэмжлэг үзүүлэх;


4.4.4.3 Монгол Улсын нутаг дэвсгэрт барилга байгууламжийн зураг төсөлд хэрэглэх үндэсний болон олон улсын тооцооны программуудыг ашиглах, зураг төслийн ажлын чанар, техникийн түвшнийг дээшлүүлэхэд анхаарах;

4.4.4.4 **Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, тэдгээртэй гэрээ байгуулах;**

4.4.4.5 **Барилга байгууламжийн зураг төсөлд дүгнэлт гаргах.**

Эх үүсвэр: Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын дүрэм

Дүрслэл 5. Барилгаа байгууламжийн зураг төсөл зохиох, хянах үйл явцын зохицуулалт (Төлөөлөх үе шат)



Тайлбар: ББЗТБМХД-Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм
Эх үүсвэр: БтХ, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм

3.4. Барилга байгууламжийн зураг төсөл, төсөвт өртөгт алдаа илэрч, дахин давтагдаж байгаа нь зураг төсөл зохиох эрх бүхий хуулийн этгээд, Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, ХББОСЯ-ны хяналтын чиг үүргүүд хэрэгжихгүй байгааг харуулж байна. Үүнд:

- **Хууль тогтоомжийн шаардлагын нийцэлд тавих хяналт сул:** Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм г.м хууль тогтоомжид нийцэхгүй ТАХ-г төлөвлөх;
- **Төлөвлөх үйл явцад тавих хяналт сул:** Нэмэлт төсөвт өртгийг төлөвлөхдөө анхны батлагдсан төсөв, гэрээнд тусгагдсан ажлыг нэмэлт ажлын төсөвт давхардуулан төлөвлөх;
- **Норм, дүрэм, стандартын хэрэгжилтэд тавих хяналт сул:** Төсөвт өртгийн тооцооллын хувьд материалын үнийг жишиг үнээс өндрөөр тооцох, материалын орц, механизмын нормчилсон машин цагийн үнэлгээг үндэслэлгүй нэмэгдүүлэх зэргээр батлагдсан норм, норматив, стандартыг мөрдөхгүй байх;
- **Төсөвт, өртгийн тооцоололд тавих хяналт сул:** Тоног төхөөрөмжийн зардлыг материалын зардлын хэсэгт тусгаж төлөвлөн нэмэлт зардал тооцох, тендерийн хэмнэлтийг хасахгүй байх, нэг ажилбарын хүрээнд хийх ажлыг тусад нь салгаж давхардуулан тооцох гэх мэт байна.

3.5. БХБС-ын 2016 оны 5 дугаар сарын 31-ны өдрийн 103 дугаар тушаалын хавсралтаар “Барилгын төсөвчний ёс зүйн дүрэм”-ийг баталж Барилгын төсөвчний ёс зүйн үндсэн зарчмууд, хүлээх хариуцлагыг тодорхойлсон байна.

3.6. Тус дүрэмд Барилгын төсөвчдийн холбооны ёс зүйн хороо төсөвчин ёс зүйн дүрмээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд дараах шийтгэл ногдуулахаар тусгасан байна. Үүнд:

- Хугацаатай даалгавар өгч сануулах;
- Төсөвчний үйл ажиллагаа явуулах эрхийг нэг жил хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх;
- Төсөвчний эрхийн гэрчилгээг хүчингүй болгох асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх;
- Ёс зүйн зөрчил гаргасан тухай тэмдэглэлийг төсөвчдийн мэдээллийн санд бүртгэх;
- Зарим тохиолдолд олон нийтэд мэдээлэхээр тусгажээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, төсөвт өртөгт тавих дотоод хяналт хангалтгүй байна

3.7. Үндэсний аудитын газраас 2023 онд хийсэн “Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл зардалд дүгнэлт гаргах” сэдэвт аудитын тайлангаар 12 ТЕЗ нарт “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, төсөвт өртөгт дотоод аудитыг тогтмол хугацаанд гүйцэтгэж хэрэгжилтийг тайлагнадаг байх” гэх зөвлөмжийг өгсөн боловч БОУАӨС, ХЗДХС, ССАЖЗС нар зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллагаагүй бөгөөд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

ӨМНӨХ АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ, АЛБАН ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТ

3.8. Үндэсний аудитын газраас 2023 онд хийсэн “Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл зардалд дүгнэлт гаргах” аудитаар 16 байгууллагад өгсөн 6 зөвлөмжийг хугацаандаа бүрэн биелүүлээгүй буюу 2025 оны 11 дүгээр сарын 01-ний байдлаар 45.6 хувийн биелэлттэй байна. Үүнд:

- ЗГХЭГ 4 зөвлөмжөөс 1 хэрэгжүүлээгүй, 3 зөвлөмжийн биелэлт 50.0 хувь;
- СЯ, ХББОСЯ, ЗТЯ, БЯ, ЭХЯ, ЭМЯ, ГБХНХЯ зөвлөмжийн биелэлт 50.0-80.0 хувь;
- ССАЖЗЯ, БОУАЯ, ХЗДХЯ хэрэгжүүлээгүй;
- ХХААХҮЯ, ГБХНХЯ-дын хэрэгжилт 100 хувь;
- ЭХҮТ ТӨХХК, ЗТХТ ТӨҮГ зөвлөмжийг 50.0 хувь хэрэгжүүлсэн бол БХТ ТӨҮГ нь хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт

№	Өгсөн зөвлөмж	Хариуцах байгууллага	Зөвлөмжийн биелэлт
1	Барилга байгууламжийн эдийн засаг, төсөв, үнэ бүрдлийн норм, нормативын баримт бичгийг шинэчлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх	ЗГХЭГ	50%
2	Төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг тооцох, магадлал хийх тогтолцоог үнэлэх, төсөвт өртөг нэмэгдэх нөхцөл байдлыг тодорхойлж, эрсдэлийг удирдах	ЗГХЭГ	30%
3	Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагаанд хяналт хийж, холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг тооцож, иргэн, хуулийн этгээдийн магадлал хийх эрх олгох үйл ажиллагаанд тэгш өрсөлдөөнийг бий болгох;	ЗГХЭГ	50%
4	Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК, Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын тогтолцооны зохистой байдалд дүгнэлт гаргаж, шаардлагатай бол чиг үүргийн өөрчлөлтийг хийх	ЗГХЭГ	0%
5	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, төсөвт өртөгт дотоод аудитыг тогтмол хугацаанд гүйцэтгэж хэрэгжилтийг тайлагнадаг байх	ХХААХҮЯ, ГБХНХЯ	100%
		СЯ, ХББОСЯ, ЗТЯ, БЯ, ЭХЯ, ЭМЯ, ГБХНХЯ	50-80%
		ССАЖЗЯ, БОУАЯ, ХЗДХЯ	0%
6	Магадлалын дүгнэлтийн нэршил янз бүр, нэгдсэн загвар маяггүй, нэмэлт ажлын магадлалын дүгнэлтэд барилга угсралтын ажлын нийт төсөвт өртгийг тусгахгүй байгаагаас үүсэж байгаа эрсдэлийг арилгаж нэгдсэн загварт оруулах, баталгаажуулах	ЭХҮТ ТӨҮГ	50%
7		БХТ ТӨҮГ	0%
8		ЗТХТ ТӨХХК	50%

3.9. Өмнөх аудитаар СЯ, ХББОСЯ, БХТ-д тус бүр 1 албан шаардлагыг хүргүүлсэн ба хэрэгжилт 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 36.7 хувьтай байна.

Хүснэгт 5. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт

№	Албан шаардлагын утга	Хариуцах байгууллага	Албан шаардлагын биелэлт
1	Төсвийн тухай хуулийн хууль болон холбогдох бусад хууль, журмын шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийг олгосон зөрчлийг арилгах	СЯ	80%
2	Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагаа, төсөвт өртөг, үнэ бүрдэлд хяналт гүйцэтгээгүй зөрчлийг арилгах	ХББОСЯ	0%
3	Алдаатай зураг төслийг магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан зөрчлийг арилгаж, зөрчил гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгах	БХТ ТӨҮГ	30%

3.10. ХББОСЯ-ны Салбарын хяналт хариуцсан нэгж нь Үндэсний аудитын газраас хүргүүлсэн албан шаардлага буюу Барилгын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсгийн дараах заалтаар хүлээсэн хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- 47.2.10 дахь заалтаар “Зураг төсөл боловсруулах, магадлал хийх, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материал үйлдвэрлэхтэй холбогдсон үйл ажиллагаанд”,
- 47.2.13 дахь заалтаар “барилга байгууламжийн төсөвт өртөг, үнэ бүрдэлд”

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хуульд тусган, баталж байгаа нь төсөвт өртөг нэмэгдэх үндсэн шалтгаан болж байна.
- Нэг маягийн болон ижил төстэй төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт суурилан төлөвлөх эсвэл тодорхой тооцоо, үндэслэлгүйгээр ойролцоо дүнгээр төсвийг төлөвлөж баталсны дараа зураг төсвийг боловсруулан магадлалаар баталгаажуулснаас шалтгаалан хуульд тусгасан төсөвт өртгийг өөрчлөх шаардлага үүсэж байна.
- Аудитаар 145 төсөл, арга хэмжээний зураг төсөл, төсөвт өртгийн нэмэгдэл зардлыг хянаж захиалагчаас ирүүлсэн саналын дүнг 163,072.2 сая төгрөг буюу 31.3 хувиар, магадлалаар баталгаажуулсан төсвийн дүнг 87,986.5 сая төгрөг буюу 19.7 хувиар тус тус бууруулав.
- Нэмэлт ажлын тоо хэмжээг тодорхойлох, төсвийг тооцохдоо ажлын тоо хэмжээг давхардуулан тооцох, материалын орц нормыг үндэслэлгүйгээр өсгөх, материалын үнийг жишиг үнээс өндрөөр тооцох, хэрэгцээ шаардлагагүй, үр ашиггүй ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөх зэрэг алдаа, зөрчил нийтлэг байна.
- Төсөл, арга хэмжээний зураг төсөл, ажлын тоо хэмжээ, төсвийн үндэслэл, тооцоололд алдаа илэрч байгаа нь захиалагчийн болон зураг төслийг хянаж, баталгаажуулах чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтнуудын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, төлөвлөх үйл явц, төсөвт өртгийн тооцоололд тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна.
- Зураг төслийн алдааг залруулахгүйгээр магадлалаар баталгаажуулж төсөвт өртгийн дүнд дүгнэлт гаргаж байгаа хяналт хийх эрх бүхий байгууллага, иргэний хариуцлагыг нэмэгдүүлж тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.
- Барилгын төсөвт өртгийн өөрчлөлтийг томсгосон хэлбэрээр тооцох аргачлалын дагуу төсөвт өртгийн тооцоонд хэрэглэх хэрэглээний үнийн индекс, валютын ханшны мэдээллийн бэлэн байдал хангагдсан боловч тус аргачлалыг улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөвт өртгийг төлөвлөх үйл ажиллагаанд мөрдөхгүй байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, төсөвт өртгийн нэмэгдэл зардлын тооцоололд салбарын хяналт хэрэгжүүлээгүй, захиалагчийн дотоод аудитыг бүрэн хийгээгүй, алдаа зөрчлийг тухай бүр арилгаагүй байна.
